



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын авто бааз" Улсын төсөвт үйлдвэрийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 230,000,000.00 (хоёр зуун гучин сая) төгрөгт багтаан 4 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Г.Баясгалан, "Засгийн газрын авто бааз" Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн
369 дугаар тогтоолын хавсралт

**"Засгийн газрын авто бааз" Улсын төсөвт үйлдвэрийн газрын
худалдан авах автомашины техникийн үзүүлэлт,
үнийн дээд хязгаар**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 3500-4000 cc	1	140,000,000.00	140,000,000.00
2	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1500-2000 cc	1	24,000,000.00	24,000,000.00
3	Суудлын тоо 11, хөдөлгүүрийн багтаамж 2000-2500 cc	1	48,000,000.00	48,000,000.00
4	Суудлын тоо 3, хөдөлгүүрийн багтаамж 2500-3000 cc	1	18,000,000.00	18,000,000.00
	Дүн		230,000,000.00 (хоёр зуун гучин сая)	230,000,000.00 (хоёр зуун гучин сая)